



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/96

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үнэлгээний хорооны 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 24 дүгээр дүгнэлтийн дагуу Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмжийн шинэчлэл (Өвөрхангай Арвайхээр, Тарагт сум) ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн 1 дүгээр багцыг 30.000.000 (гучин сая) төгрөгөөр Сэлэмконстракшн ХХК-иар, 3 дугаар багцыг 20.000.000 (хорин сая) төгрөгөөр Түшиг вилла ХХК-иар, 5 дугаар багцыг 39.976.700 (гучин есөн сая есөн зуун далан зургаан мянга долоон зуу) төгрөгөөр Маргадложистик ХХК-иар, 6 дугаар багцыг 19.880.000 (арван есөн сая найман зуун наян мянга) төгрөгөөр Тэрэмбаян ХХК-иар, 7 дугаар багцыг 29.000.000 (хорин есөн сая) төгрөгөөр Хашхан ХХК-иар тус тус гүйцэтгүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй.


2. Гэрээ байгуулан, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т үүрэг болгосугай.

4. Шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй 2, 4 дүгээр багцуудыг хүчингүй болгосугай.

5. Дээрх хүчингүй болсон багцуудыг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмаар дахин зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНБОЛД